**АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2023 оны 12 дугаар сарын 05 Тавин

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратеги төлөвлөгөөний зорилго:** Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэдийн эрүүл, аюулгүй, таатай орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх замаар хүний хөгжлийн индекс 2019 онд 0.689 байгааг 2024 онд 0.719 хүргэнэ. | | | | | | | |
| **Нэг. Бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ** | | | | | | | |
| 1 | Зорилт 1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн дундаж хувийг нэмэгдүүлнэ. | УТ | Хэрэгжилтийн дундаж хувь | 82.2 | 90-с дээш | Бодлогын баримт бичиг хэрэгжилт 92.8%-тай байна. | 92.8 |
| 1.1 | Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтээс байгууллагад хамааралтай заалтуудын биелэлтийн хангаж ажиллах | УТ | Хэрэгжилтийн хувь | 91 | 92-с дээш | Сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт 12-р сарын 05-ны урьдчилсан байдлаар 90%-ийн үзүүлэлттэй байна. | 90 |
| 1.2 | Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээний үзүүлэлтийг 90-с хувьд хүргэх | УТ | Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хувь | 85 | 90-с дээш | Ил тод байдлын мэдээллийг 98 шалгуур үзүүлэлтийн дагуу байршуулан нийт 70 заалтын хүрээнд холбогдох мэдээллийг бүрэн оруулсан. зарим заалтууд нь тус суманд хамааралгүй заалтууд байгаа болно. | 70 |
| 1.3 | Шилэн дансанд байгууллагын төсвийн мэдээллийг тогтмол оруулах | УТ | Шилэн дансанд оруулсан мэдээний хувь | 90.3 | 92 | Монгол улсын засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дугаар тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын дагуу шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулж төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Шилэн дансны мэдээ байршуулалтад Санхүүгийн хяналт дотоод аудитын алба улирал бүр хяналт шалгалт хийж 2-р улиралт 100 %, 3-р улиралд 99.9 % -тай шалгагдсан. Шилэн дансны хяналтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, Төсөвт байгууллага 6, Эм эргэлтийн сан 1 хамрагдсан. | 100 |
| 1.4 | 2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах | УТ | Хэрэгжилтийн хувь | 83 | 85-с дээш | 2023 онд Авлигын эсрэг үйл ажиллагааны 12 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвлөгөөний хэрэгжилт 86.6%-тай байна. | |
| 1.5 | Аймгийн Засаг дарга, сумын Засаг даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтийг хангаж ажиллах | УТ | Хэрэгжилтийн хувь | 87 | 90-с дээш | Аймгийн засаг дарга сумын засаг даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг тооцон Төрийн захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлсэн бөгөөд гэрээний хэрэгжилт 91.6%-тай байна. | 100 |
| 1.6 | Сумын засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах | УТ,ОНТ | Хэрэгжилтийн хувь | 77.3 | 85-с дээш | Сумын засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны хэрэгжилт 7-р сарын байдлаар 82.5%-ийн хэрэгжилттэй байсан.2023 оны жилийн эцсийн үнэлгээ эцсийн байдлаар гараагүй байна. | 97 |
| 2 | Зорилт 2. Байгууллагын хүний нөөцийг мэргэшсэн төрийн албан хаагчаар хангах, нөөцийн хэрэгцээг тогтоох, төлөвлөх, сургалтыг тодорхойлж хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажиллана | УТ | Нөхсөн сул ажлын байрны тоо | 1 | 2 | 1 сул ажлын байраа нөхсөн | 85 |
| | | | Зохион байгуулсан дотоод сургалтын тоо | 2 | 3 | Албан хаагч нарт “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай” хууль, “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”, “хөдөлмөрийн тухай хууль” сэдвээр дотоод сургалтыг зохион байгуулсан.Давхардсан тоогоор 45 албан хаагч хамрагдсан. | |
| 2.1 | Байгууллагын албан хаагчдын мэдлэг олгох, харилцан суралцах дотоод сургалтын төлөвлөгөө гарган хэрэгжилтийн зохион байгуулан ажиллах | УТ | Хамрагдсан албан хаагчдын тоо | 8 | 15 | 3 удаагийн сургалтанд 45 албан хаагч хамрагдсан. | 100 |
| | | | Сургалтын тоо | 0 | 1 | 3 | |
| 2.2 | Албан хаагчдыг гадаад сургалтууд болон мэргэшүүлэх багц сургалт, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах | УТ | Сургалтанд хамрагдсан албан хаагчдын тоо | 6 | 8 | Сумын засаг дарга, ЗДТГ-ын дарга, багийн засаг дарга нар УБ хотод “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн Шинэ сэргэлтийн бодлого “Анхан шат-2023” сургалтанд хамрагдсан.Санхүүгийн албаныхан Сангийн яам дээр 2 хоногийн сургалтанд хамрагдсан.Сумын хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүд аймагт 1 өдрийн сурагтад хамрагдсан.2023 онд давхардсан тоогоор 16 албан хаагч гадаад сургалтад хамрагдсан.Нийт 1.9 сая төгрөгийг зарцуулсан. | 100 |
| 2.3 | Байгууллагын сул ажлын байрыг хууль тогтоомжийн дагуу нөхөх | - | Нөхсөн сул ажлын байрны тоо | 0 | 1 | 2023 онд Засаг даргын тамгын газарт Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн, Байгаль орчны мэргэжилтэн, хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн,нягтлан бодогч гэсэн сул орон тоо байгаагаас | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | НБХМэргэжилтний орон тоогоо нөхөж ажилласан. | |
| 3 | Зорилт3. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангуулна | - | Ёс зүйн зөрчлийг бууруулсан хувь | 100 | 100 | 2023 оны 12-р сарын байдлаар ёсзүйн зөрчил гараагүй байна. | 100 |
| 3.1 | Ёс зүйн зөвлөлийн 2023 оны ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг тайлагнах | - | Хэрэгжилтийн хувь | 0 | 70 | Төлөвлөгөө хийгдээгүй | 0 |
| 3.2 | Ёс зүйн чиглэлээр сургалт зохион байгуулах | УТ | Сургалтын тоо | 0 | 1 | Төрийн албаны зөвлөлд төрийн албан хаагчийн ёсзүйн талаар сургалт сургалт авахаар хүсэлт тавьж дээрх хүсэлтийг хүлээн авч ЗДТГ-ын албан хаагчид төрийн албаны зөвлөл дээр “Төрийн албан хаагчийн ёсзүйн тухай хууль”-иар 2 цагийн сургалтыг авсан.<br>  | 100 |
| 4 | Зорилт 4. Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын хэрэгжилтийг нэмэгдүүлнэ. | УТ | Архивын тасгаас өгсөн үнэлгээний дундаж хувь | 78 | 90-с дээш | Архив албан хэрэг хөтлөлтийн стандартыг үйл ажиллагаандаа 100% хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100 |
| 4.1 | Байгууллагын зохион байгуулалтын нэгж, ажилтнууд “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ын дагуу баримтыг эмхлэн цэгцэлж, байгууллагын архивт шилжүүлэх | УТ | Шилжүүлсэн баримтын хувь | 100 | 100 | Жил бүрийн 1 дүгээр сард байгууллагын Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт шинэчлэн боловсруулан батлуулж нөхөн бүрдүүлэлтийг хийж хэвшсэн. | 100 |
| 4.2 | Байнга, түр, 70 жил хадгалах баримтын бүртгэлийг байгууллагын БНШК-ын хурлаар хэлэлцүүлж, баталгаажуулах | - | Батлуулсан бүртгэлийн тоо | - | 1 | Байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлийг хийж байгууллагын баримт нягтлан шалгах комиссоор хэлэлцүүлэн батлуулсан. | 100 |
| 5 | Зорилт 5. Төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж хяналт тавих, үр дүнг дээшлүүлэх, гүйцэтгэлийг тайлагнаж ажиллана. | УТ, ОНТ | Орлогын төлөвлөгөөний хувь<br>Аудитын дүгнэлтээр | 100<br>Зөрчилгүй | 100<br>Зөрчилгүй | Улс болон орон нутгийн төсвийн орлолгын жигд ханган биелүүлж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 147.2%-иний биелэлттэй байна.2022 оны санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт авсан.2023 оны тайлан дүгнэгдэх хугацаа болоогүй. | 100 |
| 5.1 | Улсын болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 100 хувь ханган биелүүлнэ | - | Биелэлтийн хувь | 100 | 100 | Улс, аймаг, орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг өссөн дүнгээр 100-аас дээш хувиар давуулан биелүүлсэн.<br><br>Үүнээс: Сумын төвлөрсөн орлого 147,2 хувь<br><br>➢ Хадгаламжийн хүүгийн орлого 109.5 %<br>➢ Улсын тэмдэгт 311.3% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ➢ Хог хаягдал 104.2 %<br>➢ Газрын төлбар 156.6 %<br>➢ Ан агнуур<br>➢ Буу 103.7%<br>➢ Малын тоо толгой 110%<br>➢ Үл хөдлөх 136.9%<br>➢ Цалин 112.8%<br>➢ ИОТТХ 20.8%<br>Аймгийн төвлөрсөн орлого 111,5 хувь<br>➢ ААНОАТ 100%<br>➢ Замын хураамж 102.2%<br>➢ Тээврийн хэрэгсэл 116.4%<br>Улсын төвлөрсөн орлого 123.4 хувийн гүйцэтгэлтэй.<br>➢ Агаарын бохирдол 100%<br>➢ ААНОАТ 113.1%<br>НӨАТ 133.2 | |
| 6 | Зорилт 6. Төсөв санхүүгийн болон худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтанд хяналт тавин ажиллана | УТ | Нийтэлсэн тендерийн эзлэх хувь | 100 | 100 | ОНХСангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээ 7 сард хийгдэж хангалттай үнэлгээ авсан.Төсөв санхүү болон х удалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаан шилэн дансны хэрэгжилтийг хангаан ажиллаж бйана. | 99 |
| | | | Хяналт шалгалтын тоо | - | 1 | | |
| 6.1 | Шилэн дансны мэдээллийг цаг тухай бүрд нь мэдээлж ажиллах | - | Шилэн дансны хэрэгжилтийн хувь | 96 | 100 | Монгол улсын засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дугаар тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын дагуу шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулж төсөв санхүүгийн ил тод байдлыг хангаан ажиллаж байна. Шилэн дансны мэдээ байршуулалтад Санхүүгийн хяналт дотоод аудитын алба улирал бүр хяналт шалгалт хийж 2-р улиралт 100 %, 3-р улиралд 99.9 % -тай шалгагдсан. | 99 |
| 6.2 | Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, эзэмшилтэнд хяналт тавьж ажиллах | - | Хяналт шалгалтын тоо | - | 1 | Сумын өмч хамгаалах зөвлөл 2023 оны төлөвлөгөөг 1-р сарын 10 ны өдөр Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Өмч хамгаалах зөвлөлийн 2023 оны тайланг хуулийн хугацаанд Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн болно.Хагас бүтэн жилээр байгууллага бүр эд | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөрөнгийн тооллогыг зохион байгуулж тайланг сумын өмч хамгаалах зөвлөлд хүргүүлэн ажиллаж байна. ЗДТГ-ын өмчид бүртгэлтэй Универсал трактор, Фермер машиныг материал бүрдүүлэн Орон нутгийн өмчийн газарт явуулж Аймгийн ИТХ-д оруулсан данснаас хасуулсан. | |
| 6.3 | Зарлагдсан тендерийн урилга, үр дүнгийн мэдээллийг вэбсайт болон пейж хуудсаар тухай бүр мэдээлэх | - | Нийтэлсэн тендерийн эзлэх хувь | 100 | 100 | Зураг төсөл,техникийн үзүүлэлт бүрэн хийгдсэн 1,Хог тээврийн машин худалдан авах,2, Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах,гүний худгийн цооног гаргах ажлуудыг тендер шалгаруулалтын цахим хэлбэрээр хийж гэрээг хугацаанд нь цахим системд оруулсан.3,59,0 сая төгрөгний Явуулын хурлын танхим тоног төхөөрөмжтэй нь худалдан авах тендерийг зарлаад байна,Зарлагдсан тендерийн урилгыг,Дундговь ,болон Адаацаг сум орон нутгийн сайт,ОНХСангийн ажилтнууд гэсэн сайтан дээр байрлуулж байна.Тендерийг цахимаар явуулж гэрээ болон ажил үйлчилгээний үйл явцыг цахим системд оруулан ажиллаж байна. | 100 |
| 6.4 | Худалдан авах ажиллагаанд үнэлгээний хорооны гишүүдийг чадавхижуулах | ОНТ | А3 сертифкаттай иргэдийн нөөц бүрдүүлэх сургалтын тоо | 1 | 1 | Худалдан авах ажиллагааны хүний нөөцийг бүрдүүлэх 2 удаагийн танхимын сургалтанд 6 хүн хамрагдаж 5 хүн шинээр тэнцэж А3 сертификат аваад байна. | 100 |
| **Хоёр. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээний хүрээнд** | | | | | | | |
| 1 | Зорилт 1. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх хугацааг 2022 онд 25 байсныг 2023 он гэхэд 20 хоногт хүргэж бууруулна. | УТ | Нэг өргөдөл шийдвэрлэлтийн дундаж хоног | 25 | 20 | 3-р улирлын байдлаар иргэнээс 299 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирснийг дундаж хоног 4,1%-тай шийдвэрлэсэн байна.<br><br>Энэ өмнө оныхоос буурсан үзүүлэлт болно. | 100 |
| 1.1 | Төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг цаг хугацаанд нь шийдвэрлэх | | Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь | 95 | 97 | 2023 оны 3 дугаар улирлын байдлаар иргэдээс нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж бичгээр 243, утсаар хандсан 40, амаар болон биечлэн уулзсан 16 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирсэн нийт 299 өргөдөл, гомдол, санал, хүсэлт /ӨГСХ/ ирүүлснээс 298 Өргөдөл, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж 99.9%-ийн гүйцэтгэлтэй ажилласан байна. | |
| 1.2 | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг erp.e-mongolia.mn системд бүртгэж, шийдвэрлэх | - | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь | 95 | 98 | Албан хэрэг хөтлөлтийн хүрээнд 93 албан бичгийг цахимаар боловсруулан тоон гарын үсгээр баталгаажуулан явуулсан албан хэрэг хөтлөлт бүрэн цахимжаад байна. мөн ирсэн бичгийг цахимаар хүлээн авч шилжүүлэн шийдвэрлэлтийг оруулан ажиллаж байна. | 100 |
| 2 | Зорилт 2. Цахимаар төрийн үйлчилгээ болон мэдээ, мэдээлэл авч байгаа иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | - | Цахимаар төрийн үйлчилгээ авсан иргэдийн тоо | 50 | 100 | E-mongolia төрийн үйлчилгээний цахим системээр иргэдэд 68 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. мөн e-mongolia операторын системээр 12 иргэнд лавлагаа үйлчилгээ үзүүлсэн байна. | 70 |
| | | | Мэдээ, мэдээлэл авсан иргэдийн тоо | 2000 | 3000 | | |
| 2.1 | Аймгийн албан ёсны цахим хаягт үйл ажиллагааны онцлох мэдээ, мэдээллийг тогтмол нийтэлж иргэдийг мэдээллээр хангах | - | Цахим хаягт оруулсан мэдээний тоо | 18 | 20 | Dundgovi.gov.mn-д нийт 54 мэдээллийг оруулсан байна. Мэдээллийг тогтмол оруулан иргэдийг мэдээ мэдээллээр хանган ажилласан. | 100 |
| 2.2 | ЗДТГ-ын албан ёсны фэйсбүүк хуудсыг чанартай ажлуулж орон нутгийн мэдээ, мэдээллийг тогтмол мэдээлж хэвших | - | Дагагчдын тоо | 100 | 1000 | ЗДТГ-ын цахим фэйж хуудсанд сүүлийн хагас жилд 74 мэдээ оруулж хандалтын тоо давхардсан тоогоор 200,956 байн а. | 100 |
| | | | Мэдээллийн тоо | 50 | 60 | | |
| 2.3 | E-mongolia төрийн үйлчилгээний цахим системийг иргэдэд сурталчилж, хэрэглэгчдийн тоог нэмэглүүлэх | - | Сурталчилсан тоо | 2 | 5 | E-mongolia төрийн үйлчилгээний цахим системээр иргэдэд 68 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. мөн e-mongolia операторын системээр 12 иргэнд лавлагаа үйлчилгээ үзүүлсэн байна. | 100 |
| | | | Үйлчилгээ авсан иргэдийн тоо | 35 | 70 | | |
| 3 | Зорилт 3. Батлан хамгаалах болон гамшгаас хамгаалах хууль, тогтоомжийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж бодлого зохицуулалтаар хангана | УТ 0.5 сая | Хууль, тогтоомжийн хэрэгжилтийн хувь | 90-с дээш | 90-с дээш | Сум орон нутагтаа батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг тухай бүр хангаж Цэргийн тоо бүртгэл, Цэрэгт татлага болон орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг тухай бүр тодотгон бэлэн байдлыг ханган ажиллаж байна. | 100 |
| 3.1 | Орон нутгийн хамгаалалтын томилгоот бүрэлдэхүүний томилгоог тодотгох | - | Тодотголын хувь | 100 | 100 | Орон нутгийн хамгаалалтын томилгоот бүрэлдэхүүнийг тухай бүр тодотгон бэлэн байдлыг ханган ажиллаж байна. | 100 |
| 3.2 | Цэргийн бүртгэл, цэрэг татлагын ажлыг зохион байгуулах | ОНТ | Цэрэг татлагаар орсон залуучуудын тоо | 35 | - | 2023 оны намрын 2-р ээлжийн цэрэг татлага сумand 2023.10.07-ны өдөр зохион байгуулагдаж цэрэг татлагын товчоогоор 41 цэргийн залуу орж үүнээс 16 залуу цэргийн албанд тэнцсэн. | 100 |
| | | | Бүртгэлд хамрагдсан иргэдийн хувь | 50 | 90-с дээш | | |
| 3.3 | Гамшигтай тэмцэх чадвахыг сайжруулах | ОНТ | Дадлага, сургууль зохион байгуулагдсан тоо | 1 | 1 | Манай суманд 2023.09.16-17-ны өдрүүдэд Аймгийн засаг даргын нэрэмжит “Команд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | штаб"-ын сургуулилт амжилттай зохион байгуулагдаж дууссан. | |
| 4 | Зорилт 4. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчиилгааг иргэдийн 15 хувьд хүргэнэ. | ОНТ | Хамрагдсан иргэдийн эзлэх хувь | 5 | 10 | 2023 онд иргэдэд сурталчлах хууль эрхзүйн 16 заалт бүхий сургалтын төлөвлөгөөг боловсруулан иргэдэд сургалтыг зохион байгуулж байна.2023 оны 11 сарын байдлаар 7 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 294 иргэн хамрагдсан бөгөөд нийт иргэдийн 11.7% хамрагдсан байна. | 100 |
| 4.1 | Эрх зүйн хөтөч нартай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх, олон нийтийг хамарсан арга хэмжээ, сургалтыг зохион байгуулах | ОНТ | Гэрээний хэрэгжилтийн хувь | 70 | 80 | Өнөөдрийн байдлаар 2 бэлтгэгдсэн эрхзүйн хөтөч ажиллаж байгаа бөгөөд гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. | 70 |
| 4.2 | ТАХ-дын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх болон иргэдэд хууль тогтоомжийг сурталчлах, сургалт зохион байгуулах | ОНТ | Сургалтын тоо | 0 | 2 | 7 удаагийн сургалтыг зохион байгуулсан. | 100 |
| | | | Иргэдийн тоо | 162 | 250 | Нийт 294 иргэн | 100 |
| 5 | Зорилт 5. Иргэдийн оролцоог хангаж ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлж, эрүүл амьдрах таатай орчныг бүрдүүлэх | УТ, ОНТ, | Иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны хувиар | 30 | 70-ээс дээш | Сэтгэл ханамжийн судалгаа хийгдээгүй. | 0 |
| 5.1 | Хог ангилан ялгах хогийн савны тоог нэмэгдүүлэх | ОНТ | Хогийн савны тоо | 0 | 5 | Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан болон ОНХСангийн хөрөнгө 4290000 төгрөгний санхүүжилтээр төсвийн 5 байгууллагга хүүхдийн тоглоомын талбайд нийт 6ш ангилан ялгах хогийн сав байрлуулан ажилласан. | 100 |
| 5.2 | Иргэн, хувийн хэвшилтэй хамтран ногоон байгууламжийг нэмэгдүүлэх | ОНТ | Тарьсан модны тоо | 500 | 1500 | Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, МУ-ын ерөнхийлөгчийн зарлиг бүх нийтээр мод тарих өдрийг тохиолдуулан сумын хэмжээнд 2,5 га талбайд Хаврын тариалалт 1500ш намрын тариалалтаар 620 нийт 2120 мод тарих ажлыг хийж гүйцэтгэлээ ургалт 90%. Дээрх ажлыг ХХҮГазраас 10 иргэнийг түр ажлын байраар хангаж ажилласан. | 100 |
| 6 | Зорилт 6. Мал үржлийн ажил үйлчилгээ, бүртгэлийг зохион байгуулах, сурталчлах, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн бэлтгэлийн стандартыг хангуулах, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлхэд анхаарч ажиллана . | | Бүртгэлд хамрагдсан малын тоо | 500 | 800 | 2023 онд ОНХСангийн хөрөнгө 74 сая төгрөгөөр 4 багт 4 худаг гаргасан.Малын үржил бүртгэлийн ажлыг зохион байгуулж 6 суурьт ялган ангилалт хийж нийт 919 малыг ээмэгжүүлэн бүртгэлд хамруулсан. | 100 |
| | | | Хяналт шалгалтын тоо | 1 | 1 | | |
| | | | худгийн тоо | 2 | 4 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.1 | Өвөлжилт хаваржилтийн бэлтгэл хангах | ОНТ | Өвөлжилтийн бэлтгэл хангасан хувь | 80 | 90 | Сумын 2023-2024 оны Хөдөө аж ахуйн болон төв суурин гарзын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хэсэг болон төлөвлөгөөг сумын Засаг даргын 2023.08.31 өдрийн А/80 тоот захирамжаар гарган төлөвлөгөөний хэрэгжилт өнөөдрийн байдлаар 87%-тай байгаа бөгөөд хэрэгжилтийг холбогдох газар хүргүүлэн ажилласан.Сумын ЗДТГ-1000 боодол нарийн өвс,4000 боодол ногоон тэжээл,Амьдралын туг 2800 боодол,Иргэд 4000 боодол ногоон тэжээл,малчил 163 тн тэжээл өвс бэлтгээд байна. | 85 |
| 6.2 | Бэлчээрийн хортон мэрэгч амьтан, шавжтай тэмцэх ажлыг зохион байгуулах | УТ,ОНТ | Тухайн жилийн тэмцсэн талбайн хэмжээ/мян.га/ | 2000 | 4000 | Бэлчээрийн хортон мэрэгчтэй микробиологийн аргаар тэмцэх ажлын хүрээнд ХХААХҮЯ- аас4тн бактержуулсан будаа ний лүүлсний дагуу хөдөө гийн4 багийн2000 га талбайд будаа цацах ажлыг багийн дарга, малчид, ХХҮГ- аас10 иргэнийг түр ажлын байраар ханган хамтран зохион байгуулан ажилласан. Тайлан холбогдох бичиг баримтыг ХХААГазарт хүргүүлэн ажиласан.Энгийн механик аргаар хийж гүйцэтгэх ажлын хүрээнд1ш үлий цөмлөгч, 2ш утагч багажаар хангагдсан.Намрын оготоно устгал цаг агаарын нөхцөл байдлаас болоод хийгдээгүй. | 50 |
| 6.3 | Мал аж ахуйн үйлдвэрлэлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулахад малчдыг санал асуулгад идвэхитэй оролцуулах | ОНТ | Хамрагдсан малчдын тоо | 0 | 20 | Аймгийн хэмжээнд Мал аж ахуйн дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд дээрх ажлын хэсэгнийт 50 малчин өрхөөс судалгаа авч ажилласан. | 100 |
| 6.4 | Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх энгийн болон гүн өрмийн худаг шинээр гаргах | ОНТ<br>УТ | Шинээр гаргасан худгийн тоо | 3 | 4 | 2023 онд ОНХСангийн хөрөнгө 74 сая төгрөгөөр 4 худгийг гаргаж ажлын хэсэг хүлээн авсан. | 100 |
| 7 | Зорилт 8. Бэлчээр газар тариалангийн чиглэлээр гарсан хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулж, тайлагнана. | ОНТ, төсөл хөтөлбөр | Хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн тоо | 0 | 1 | Ю-Пи-Си Реньюбелс Монголиа ХХК нь “Дундговь-Бэлчээрийн нөхөн сэргээлт” төслийн хүрээнд манай сумын Адаацаг сумын хоёр багт бэлчээрийг нөхөн сэргээх төлөвлөгөө боловсруулан Нөхөн сэргэх | 30 |
| | | | Хэрэгжилийн хувь | 0 | 70-с дээш | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боломжийг үнэлэх зорилгоор бэлчээрийг түр хаших туршилт хийгдсэн.Нийтдээ 80 сая төгрөгийн төсөл хэрэгжинэ. | |
| 7.1 | Жил бүр бэлчээрийн даац тодорхойлох ургамлын тооллого, фотомониторнг хийх | УТ<br>0.2 сая | Тооллогын тоо | 1 | 1 | Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг 2023 оны 8 дугаар сарын 3,4-ны өдрүүдэд 4 багт нийт 20 мониторингийн цэгт хээрийн болон суурин судалгааны ажлыг хийж гүйцэтгэн 2023 оны бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлсэн ажлын үр дүн тайланг аймгийн ГХБХБГазарт хүргүүлсэн. | 100 |
| 7.2 | Хүнсний ногоо, тэжээлийн ургамал жимс жимсгэний мод тариалалтыг нэмэгдүүлж, нэгж тайлбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх | Иргэд ААНБ | Тариалсан талбайн хэмжээ га | 1.5 | 2 | 2023 онд төмс 0.7га,хүнсний ногоо 0.889 га,жимс, жимсгэнэ 0.25 га нийт 1.839 га-д тариалсан.Төмс 2 тн, хүнсний ногоо 2.867 тн, жимс жимсгэнэ 0.323 тн нийт 5.19 тн ургац хураасан байна. | 100 |
| | | | Ургацын хэмжээ тн | 5тн | - | | |
| 8 | Зорилт 9. Нийгмийн хамгаалал, халамж үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг хангуулах, үр дүнг тайлагнах | УТ | Ажлын байрны тоо | 15 | 20 | 2023 онд түр ажлын байраар Оготоно устгал хийхэд 10 иргэн, Мод тарих ажилд 10 иргэн нийт 20 иргэнийг хангаж ажлын байранд зуучилсан. | 100 |
| | | | Нийгмийн даатгалын хамрагдалтын хувь | 30 | 47 | Сайн дурын даатгалд хамрагдах нийт иргэдийн 67%-ийг хамруулаад байна. | |
| 8.1 | Сумын хүн амын нийгмийн даатгалд хамрагдалтын хувийг нэмэгдүүлнэ. | УТ | Нийгмийн даатгалын хамрагдалтын хувь | 30 | 47 | Сайн дурын нийгмийн даатгалд 226 иргэн хамруулан 113052582 төгрөгийн орлого биелүүлэн. Сар бүр мэдээгээ өгч СДД-ын хамралт болон нийгмийн даатгалын орлогоо жигд ханган ажиллаж байна.Хамрагдалт 67%-тай байна. | 100 |
| 8.2 | Сумын хүн амын зорилтот бүлэг, нийгмийн халамж дэмжлэг зайлшгүй шаардлагатай иргэдийг байнгын болон түр ажлын байраар хангана. | УТ | Байнгын болон түр ажлын байраар хангагдсан иргэдийн тоо | 15 | 20 | 2023 онд түр ажлын байраар Оготоно устгал хийхэд 10 иргэн, Мод тарих ажилд 10 иргэн нийт 20 иргэнийг хангаж ажлын байранд зуучилсан.Байнгын ажлын байранд 6 иргэнийг зуучилсан. | 100 |
| 8.3 | Хүүхэд гэр бүлийн мэдээллийн санд бүртгэлтэй, эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдүүдийг судлан тогтоох,хүүхдийн аюулгүй | ОНТ | Үйлчилгээ үзүүлсэн хүүхдийн хувь | 0 | 100 | Сумын хэмжээнд Хүчирхийлэлд өртөж болзошгүй эрсдэлтэй хүүхэд, гэр бүлийг шинээр илрүүлэх, мэдээлэх хэрэгжүүлэх, хүчирхийллийг таслан зогсоох үйл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байдлыг хангах, шаардлагатай тусламж үйлчилгээнд хамруулах | | | | | ажиллагааг зохион байгуулан ажилласан. Хүчирхийлэлд өртөж, болзошгүй 43 хүүхэд байгааг судалгаагаар олж тогтоогоод байна.2023 он гарсаар хүүхдийн тусламжийн утас 108-д 1 гомдол очиж үүний дагуу хамтарсан баг хуралдаж асуудлыг шийдвэрлэсэн. Мөн гэр бүлийн маргааны талаар гомдол цагдаагийн байгууллага дээр 1 бүртгэгдсэн. Үүний дагуу хамтарсан баг кейс нээж ажиллаж байна. | |
| 8.4 | Гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн хөгжлийг дэмжих сургалт, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах | | Хөгжөөнт уралдаан тэмцээнд оролцсон өрхийн хувь | 0 | 5 | Гэр бүлийн боловсрол олгох сургалтыг Багийн иргэдийн нийтийн хурлын үеэр малчид ард иргэдэд мэдээлэл хүргэж, сургалт зохион байгуулан ажилласан. Сургалтад нийт 160 өрхийн 250 иргэн хамрагдаж гэр бүлийн хүчирхийлэл болон хамтарсан багийн талаар мэдээллийг хүлээн авсан. Эцэг эхийн дунд “Аха” тэмцээн уралдаан зохион байгуулан ард иргэд идэвхтэй хамрагдсан. | 100 |
| | | | Сургалт нөлөөллийн ажилд хамрагдсан өрхийн хувь | 0 | 5 | Хамтарсан багийн үйл ажиллагааг иргэдэд цахимаар болон багийн иргэдийн нийтийн хурлаар танилцуулж ажилласан. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль,” “Хүүхэд хамгааллын тухай хууль” болон бусад хуулийг сумын НБХМ нийт 43 иргэнд мэдээлэл хийж иргэдэд хуулийн талаар болон хамтарсан багийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хийсэн.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль,” “Хүүхэд хамгааллын тухай хуулийн талаар “Танин мэдэхүйн” тэмцээн зохион байгуулсан. Нийт-18 иргэн оролцсон. | 70 |
| 8.5 | Ахмад настны эрхийг хангах, эрүүл мэнд оролцоог дэмжих, нийгмийн үйлчилгээнд хамруулна. | ОНТ | Нийгмийн үйлчилгээнд хамрагдсан ахмадын хувь | 50 | 70 | 2023 онд ахмадын амралт сувилалд 41 ахмад хамрагдсан.Мөн сар бүрийн 15-нд төрийн байгууллагууд хуваарийн дагуу ахмадын дунд “Ахмадын дуун цэнгүүн” арга хэмжээг зохион байгуулдаг ахмадууд маш идэвхитэй хамрагддаг.Жил бүрийн ахмадын баяраар ахмадуудын дунд спортын уралдаан тэмцээнийг зохион | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулдаг бөгөөд 2023 онд арга хэмжээнд 86 ахмад оролцсон.Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээнд 173 ахмад настан хамрагдсан байна.Нийт ахмадын 82.1% хамрагдсан байна. | |
| 8.6 | Залуучуудыг сум орон нутгийнхаа хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлж тэдний оролцоог нэмэгдүүлэх | - | Залуучуудын оролцооны хувь | 10 | 50 | “Залуучуудын хөгжлийн зөвлөл“-ийг сумын засаг даргын 2023.07.25-ны өдрийн А/72 захирамжийн дагуу 12-н хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна.Залуучуудын зөвлөл “Бага олимп” арга хэмжээнд оролцох бэлтгэл ажлыг хангасан.Нийт 40 залуу тамирчид оролцсон. | 30 |
| | Зорилтын дундаж үнэлгээ | | | | | | 81.9 |
| | Арга хэмжээний дундаж үнэлгээ | | | | | | 90.7 |

*Төлөвлөгөөг хянасан:* ***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

Засаг дарга ......................... /Ч.Уранчимэг /

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг* ...............................

*Төлөвлөгөө тайлагнасан:* ***Төсвийн Шууд захирагч***

ЗДТГ-ын дарга ......................... /Б.Уранцэцэг /

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг* ...............................

Адаацаг сумын ЗДТГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дүнгийн нэгтгэл

| № | сумын нэр | Зорилт | | Арга хэмжээ | | 2023 оны хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | тоо | хувь | тоо | хувь | |
| 1 | Адаацаг сум | 14 | 81.9 | 42 | 90.7 | 127.25 |
| | | | | | | |